



ХОВД АЙМГИЙН БАНКНЫ САЛБАР, НЭГЖҮҮДИЙН 2013 ОНЫ

2 ДУГААР УЛИРЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН

ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Банкны салбар нэгжүүд:

Аймгийн хэмжээнд 6 арилжааны банкны 50 салбар, нэгжүүд харилцагч, вйлчлүүлэгчиддээ банк санхүүгийн вйлчилгээг хүргэж байна. Салбар нэгжийн тоо омох оны мон вeэс 1 нэгжээр буюу 1 тооцооны кассаар нэмэгджээ. Тайлант улиралд банкны ажилчдын тоо 274-д хүрч омох оны мон вeэс 8 ажилтнаар осчээ. Банкны нийт ажилчдын

51.1 хувь нь ходоо сумдын тооцооны товд, 48.9 хувь нь аймгийн

товийн салбар нэгжүүдэд ажиллаж байна. Нийт ажилчдын 87.8 хувь нь дээд, 4 хувь нь тусгай дунд, 8.2 хувь нь бүрэн дунд боловсролтой ажилчид ажиллаж байна. Ажилчдын боловсролын түвшинг омнох оны мон үетэй харьцуулахад дээд боловсролтой ажилчдын тоо омнох оны мон үеэс 5 хvнээр нэмэгдсэн бол бусад боловсролын (тусгай дунд, бүрэн дунд, бусад) хувьд буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь банкуудын вйл ажиллагаа оргожихийн хирээр мэргэжлийн ажилчдын тоо нэмэгдэн хvний нооцийн асуудлыг шийдвэрлэхэд зохих ахиц оорчлолт гарсныг харуулж байна.

Арилжааны банкууд энэ улирлын байдлаар нийт 23.8 тэрбум тогрогийн зузаатгалыг Монголбанкнаас авч 28.1 тэрбум тогрогийн зузаатгалыг Монголбанкинд тушааж 3.2 тэрбум тогрогийн түргэн борлогдох активын үлдэгдэлтэй гарсанаар касс дахь бэлэн монгоний зайлшгүй байх нооцийн хэмжээг хангаж ажиллажээ.

Тайлант улиралд банкуудын нийт актив хоронгийн хэмжээ омнох оны мон үеэс 16.8 тэрбум тогрогоор нэмэгдэж 85.5 тэрбум тогрогт хүрсэн богоод үвний 78.5 тэрбум тогрог буюу 91.8 хувийг зээлийн багц эзэлж байна.

□□ **Зээлийн талаар:**

Аймгийн хэмжээнд 18234 иргэд, аж ахуй нэгж байгууллага орхийн хэрэгцээ болон явуулж буй вйл ажиллагаагаа оргожүүлэх чиглэлээр зээлийн вйл ажиллагаанд хамрагдан вйлчлүүлж байгаагаас ХААН банкинд нийт зээлдэгчийн дийлэнх буюу 43.7 хувь, Хадгаламж банкинд 24.5 хувь, ХАС банкинд 12.7, Голомт банкинд 11.7 хувь, бусад банкинд 7.4 хувь нь хамрагдаж байна. Нийт зээлдэгчийн тоо омнох оны мон үеэс 1059 зээлдэгчээр оссон бол омнох улирлаас 1684 зээлдэгчээр буурчээ. Зээлийн багц омнох оны мон үеэс 37.6 хувиар нэмэгдсэн нь боловсруулах вйлдвэрлэл буюу тослийн зээл, үл ходлох хоронго барьцаалсан зээл, орхийн хэрэглээ, цалингийн зэрэг бүтээгдэхүүний багц нэмэгдсэнтэй холбоотой байна. Мон нийт зээлийн багцын нэг зээлдэгчид ногдох дундаж зээлийн хэмжээг тооцоход 4.3 сая тогрог байгаа нь омнох оны мон үеэс 800.0 мянган тогрогоор нэмэгдсэн байна.

Нийт зээлийн багцын 0.25 хувийг хугацаа хэтэрсэн, 0.43 хувийг чанаргүй зээлийн

орийн үлдэгдлүүд эзлээд байна. Чанаргвй зээлийн хэмжээ омнох оны мон вед 1.3 тэрбум тогрогт хврч байсан бол энэ оны эхний хагас жилийн байдлаар 338.4 сая тогрогт хврч омнох оны мон веэс 987.4 сая тогрогоор буурсан нь арилжааны банкууд чанаргвй зээлийг бууруулах талаар тодорхой ажил зохион байгуулан ажилсны үр дүнг харуулж байна. Зээлийн багц болон чанарын үзүүлэлтийг баруун бүсийн аймгуудтай харьцуулан харуулбал:

Хүснэгт 1. Баруун бүсийн хэмжээний зээлийн чанарын үзүүлэлт (аймгуудаар)

(2013 оны 2 дугаар улирал)

сая.тог

Аймгийн нэр Чанаргвй	Нийт зээл бүсэд	эзлэх хувь	Хугацаа хэтэрсэн бүсэд	эзлэх хувь
Ховд	78,521.3	20.4	193.9	11.3
Завхан	70,092.5	18.2	167.6	9.8
Увс	102,542.6	26.6	370.7	21.7

Баян-Олгий	81,923.0	21.3	754.5	44.1	599.3	33.9
Говь-Алтай	51,661.5	13.5	224.9	13.1	147.4	8.3
Бүгд	384,740.9	100.0	1,711.6	100.0	1,766.4	100.0

Манай аймгийн банкуудын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл бүсийн аймгуудын үзүүлэлттэй харьцуулахад бууралттай байна.

Малчны зээлийн бүтээгдэхүүний талаар:

Аймгийн хэмжээнд ХААН банк, Хадгаламж банкууд оорсдийн салбар нэгжүүдээр дамжуулан малчдын орхийн хэрэглээ, арилжаанд зориулан малчны зээлийг олгож байна. Тайлант улирлын байдлаар малчны зээлийн бүтээгдэхүүний багц 4.1 тэрбум тогрогт хүрсэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум тогрогоор өссөн бөгөөд нийт зээлийн багцын 5.2 хувийг эзлээд байна.

Аймгийн 2012 оны статистик үзүүлэлтээр 7320 малчин орх тоологдсоноос 2854 орх буюу 38.9 хувь нь банкны салбар, нэгжүүдэд зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.3 хувиар буурчээ. Үүнээс үзэхэд зээлтэй нэг малчин орход дундажаар 1.4 сая тогрогийн зээл ногдож байна. Аймгийн хэмжээнд нийт зээлтэй малчин орхийн 409 зээлдэгч орх нь Хадгаламж банкинд 547.2 сая тогрог, 2854 зээлдэгч орх нь ХААН банкинд 3.6 тэрбум тогрогийн зээлийн үлдэгдэлтэй байна. /Дэлгэрэнгүй судалгааг 1 дүгээр хавсралтаар харуулав./ Мөн малчдын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх

оны мон веес 263.5 сая тогрогоор буурч 153.3 сая тогрогт хүрсэн үзвэлтэй байна. Энэ нь малчдын зээл 2009-2010 онуудад маш их хэмжээгээр хугацаа хэтрэн чанаргүй болж хууль хяналтын байгууллагуудад шилжин, банкуудад маш их хэмжээний эрсдэл хүлээлгэж, улс орны хэмжээнд анхаарал татаж байсан бол 2011 оноос хойш олгогдсон зээлүүдээс чанаргүй зээл гарахгүй байгаа нь малчдын амьжиргааны түвшин дээшилж, зовхон оорийн хэрэгцээндээ тохируулан авах, авсан зээлээ зориулалтын дагуу ашиглаж байгаатай холбоотой байна.

Мон аймгийн хэмжээний нийт зээлтэй малчин орхүүдийн 31 зээлдэгчийн 44.0 сая тогрогийн зээлийн үлдэгдэл аймгийн товд, 2823 зээлдэгчийн 4.1 тэрбум тогрогийн зээл ходоо сумуудад байршиж байна.

Малчны зээлийн бүтээгдэхүүний чанаргүй зээлийн үзвэлт нь аймгийн хэмжээний нийт чанаргүй зээлийн 45.2 хувийг эзэлж байна. Үүнээс үзэхэд малчны чанаргүй зээлийн хэмжээ 2008, 2009, 2010 онуудтай харьцуулахад буурч чанарын үзвэлт сайжирсан нь байгаль цаг уурын ноцол байдал сайн байсантай уялдан малын зүй бус хорогдол буурч малын тоо толгой оссон, мал болон мал аж ахуйн гаралтай түвхий эдийн үнэ оссон, тор засгаас зохих урамшуулал олгож эхэлсэн зэргээс малчдын амьжиргааны түвшин эрс сайжирсантай холбоотой гэж үзэж байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийн бүтээгдэхүүний талаар:

Засгийн газар, Жижиг дунд үйлдвэрлэлийн газраас хэрэгжүүлж буй жижиг дунд үйлдвэрлэлийн тослийн зээлийг орон нутгийн банкуудаар дамжуулан олгож байгаа богоод тайлант улирлын байдлаар 120 зээлдэгчийн 3.5 тэрбум тогрогийн зээлийн үлдэгдэлтэй байна. Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Жижиг дунд үйлдвэрлэлийн тослийн зээлийн үлдэгдэл нь аймгийн хэмжээний нийт зээлийн багцын 4.4 хувийг эзэлж байгаа богоод тайлант хугацааны байдлаар 2 зээлдэгчийн 800.0 мянган тогрогийн зээл чанаргүй зээлийн ангилалд байна. Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр зээл олгогдож эхэлснээс хойш 2010, 2011 онуудад зээлийн чанар муудах хандлагатай болж байсан бол тайлант онд чанарын үзвэлт сайжирсан боловч зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа зээлүүд гарч байна. Иймд энэ чиглэлээр олгогдож байгаа болон олгосон зээлийн үр дүнг явцын хяналтаар баталгаажуулан хийж үйл ажиллагаатай нь танилцаж эрсдэл үүсэхгүй байх талаар хамтран ажиллах шаардлагатай байна.

Төрийн албан хаагчдын зээлийн талаар:

Мон торийн захиргааны жинхэнэ болон торийн үйлчилгээний албанд ажилладаг 4675 зээлдэгчийн 18.8 тэрбум тогрогийн зээл байгаагаас тайлант улирлын байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн ангилалд 15 зээлдэгчийн 18.2 сая, чанаргүй зээлийн ангилалд 14 зээлдэгчийн 16.3 сая тогрогийн зээл шилжсэн нь аймгийн хэмжээний нийт чанаргүй зээлийн 3.7 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь омнох оны мон үетэй харьцуулахад 4.7 хувиар буурчээ.

Ипотекийн зээлийн талаар

Тайлант оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 435 зээлдэгчийн 8.2 тэмбум тогрогийн зээлийн үлдэгдэл байршиж байна. Монголбанк, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа иргэдийг орон сууцжуулах жилийн 8 хувийн хүүтэй орон сууцны зээлийн талаар аймаг орон нутгийн удирдлагууд болон банкны салбарын захирлуудтай уулзалт зохион байгуулж Ховд аймгийн Монголбанкны салбараас 2013 оны 2 дугаар улиралд орон сууцны ипотекийн зээлийг хэрэгжүүлэх сурталчилах талаар дараах ажлуудыг хийлээ. Үүнд: Банкны эдийн засагч болон теллерүүдийн сургалтанд Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа дэд хотолборүүдийн 1 болох орон сууцны 8 хувийн хүүтэй зээлийг иргэд харилцагчдад хүндрэл учруулахгүйгээр олгох талаар бэлтгэл ажлуудыг хангах, энэ талаар орон нутгийн иргэдэд сурталчилах ажлыг зохион байгуулах үүрэг оглоо. Аймгийн Ховдын мэдээ сонины 6-р сарын дугаарт "Орон сууцны жилийн 8 хувийн хүүтэй зээлийг олгож эхэллээ" сэдэвт мэдээлэл нийтлүүлээ. Үр дүнд нь аймгийн хэмжээгээр 16-18 хувьтай байсан нийт орон сууцны зээлийн 200 зээлдэгчийн 4.1 тэрбум тогрогийн зээлийн үлдэгдлийг шилжүүлсэн. Энэ нь нийт шилжүүлэх зээлийн 85 хувийг эзэлж байна. Мон Шилжүүлэгдээгүй үлдсэн 15 хувь нь харилцагч иргэдээс оорсдоос нь шалтгаалсан, Хадгаламж банк шилжүүлж эхлээгүйтэй холбоотой байсан. Энэ оны эхний хагас жилд багтааж жилийн 8 хувийн хүүтэй орон сууцны ипотекийн зээлд 38 зээлдэгчийн 1.1 тэр бум тогрог олгоод байна.

Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн талаар:

Банкны харилцах дансны үлдэгдэл омнох оны мон үеэс 1.1 тэрбум тогроогоор буурч 16.2 тэрбум тогрогт хүрлээ. Нийт харилцах дансдын 99.8 хувийг тогрогийн харилцах, 0.2 хувийг валютын харилцах дансдууд (валютыг тогрогт хөрвүүлснээр) эзэлж байна. Мон харилцах дансдын нийт үлдэгдлийг омчийн хэлбэрээр нь ангилж үзвэл: улсын байгууллага 26.8 хувь, хувийн хэвшил 18.3 хувь, иргэдийнх 54.9 хувийг тус тус эзлээд

байна. Харилцах дансдын осолтийн еронхий хандлагыг судалж үзвэл: тороос үзүүлж байгаа халамж, тэтгэмжтэй холбоотой осолт багагви хувийг эзэлж байна.

Хадгаламжийн үлдэгдэл омнох оны мон үеэс 7.9 тэрбум тогрогоор осч 40.4 тэрбум тогрогт хүрчээ. Нийт хадгаламжийн 65.4 хувийг 26.4 тэрбум тогрогийн хугацаатай хадгаламж, 34.6 хувийг 14.0 тэрбум тогрогийн хугацаагви хадгаламжийн үлдэгдэлүүд эзэлж байна. Үүнээс үзэхэд аймгийн хэмжээнд 1 хадгаламж эзэмшигчид дундажаар 700.0 мянган тогрог ногдож байгаа нь омнох улирлаас 300.0 мянган тогрогоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Үүнээс үзэхэд бусдаас татан товлорүүлсэн хоронгийн дотор хадгаламж ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн нь Засгийн газраас олгосон эх орны хишиг сангийн монго иргэдэд тараагдсантай холбоотой боловч ихэнх ард иргэдийн гар дээр сул чолоотэй монгон хоронгийн илүүдэл нилээд байгаа нь ард түмний амьдрал дээшилж байгааг харуулах нэгэн үзүүлэлт юм. Татан товлорүүлсэн хоронгийн хэмжээ нэмэгдэж байгаа нь ард иргэдээс банкинд итгэх итгэл сайжирч банкны тогтвортой байдал хангагдахад сайнаар нолоолох болно.

Бэлэн бус төлбөр тооцооны талаар:

Арилжааны банкууд орон нутагт ажил үйлчилгээг түргэн шуурхай, эрсдэлгви болгох үүднээс оорсдийн торол бүрийн бэлэн бус толбор тооцоог нэвтрүүлэн харилцагч, үйлчлүүлэгч нартаа хүргэн ажиллаж байна. Тайлант хугацааны байдлаар банкуудын 145847 харилцагчдын 98.1 хувь нь иргэдийн харилцагч байгаа богоод үүний 39.6 хувь буюу 57844 мянган иргэд бэлэн бус толбор тооцооны системд шилжсэн байна. Цахим банкаар үйлчлүүлэгчдийн тоо омнох оны мон үеэс 12.3 мянган харилцагчаар нэмэгдсэн богоод зоогийн газар болон үйлдвэр үйлчилгээний зориулалттай газруудад тавигдсан POS, POB машинаар хийгдэж буй бэлэн бус толбор тооцооны гүйлгээ эрс нэмэгдсэн байгаа нь харилцагчид эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлэн монгоний урсгалыг багасгаж, бэлэн бус толбор тооцоонд шилжих вил ажиллагаа идэвхитэй явагдаж байгааг харуулж байна. Мон картын хэрэглээ нэмэгдсэн байгаа нь нэг талаас банкууд картын вил ажиллагаагаа оргожүүлсэн, ногоо талаас Монголбанкны зүгээс бэлэн бус толбор тооцооны хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх бодлогыг баримталж, банкуудтай хамтран үндэсний толборийн карт гаргаж, түүний хэрэглээг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбоотой юм.

Валютын ханш, инфляцын талаар:

Тайлант улирлын байдлаар тогрогийн америк доллартай харьцах зарах ханш 1,342.23 тогрог болж омнох оны мон вeэс 14.13, юаны ханш 234.40 тогрогт хvрч омнох оны мон вeэс тогрогийн ханш 25.72 нэгжээр тус тус суларсан ханш суларсан байна.

Мон зээл, хоронго оруулалтыг нэмэгдvүлэх, эдийн засгийн бодит сектор, бизнесийн идэвхжилийг дэмжих зорилгоор монгоний бодлогын хvүг 1.0 нэгж хувиар бууруулж 10.5 хувь болголоо. Улсын тосвийн инфляцид вэвүлэх дарамт бага, улмаар эрэлтийн болон нийлвүлэлтийн гаралтай инфляцийн нолоолол багасч, жилийн инфляци ирэх саруудад энэ оны зорилтот тvвшинтэй нийцэж байгаа нь монгоний бодлогын хvүг бууруулах боломжийг бvрдvүлж байна. Тайлант хугацааны байдлаар инфляци 8.8 хувьтай байна.

Ийнхvү монгоний бодлогын хvүг бууруулснаар арилжааны банкууд зээлийн хvүгээ бууруулах нохцол боломж нээгдэж байгаа богоод энэхvү хvүлээлт энэ оны 2 дугаар улирлаас эхлэн зохих хэмжээгээр шийдвэрлэгдэж бизнес эрхлэгчдийн хувьд таатай орчин бvрдэж байна.